

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**ХКН-ЫН XII ИХ ХУРЛЫН ДАРААХ «ОДООЧИЛСОН МАОИЗМ»
ГЭГЧ АСУУДЛААР ХИЙЖ БУЙ СУДАЛГАА**

БНСВУ-ын Нийгмийн Ухааны Хорооны
Ази, Номхон далайн судлалын газрын
дарга **Ван Чонг**

Сүүлийн жилүүдэд БНСВУ-ын Хятад судлалын эрдэм шинжилгээний байгууллагууд Хятадын асуудлаар төрөл бүрийн арга хэмжээ зохиож ирэв. Тухайлбал: ХКН-ын XII их хурал (1982 оны 9-р сар) хятадын орчин үеийн улс төр, нийгэм-эдийн засгийн байдал, төрийн байгуулал, «Дөрвөн шинэчлэлт»-ийн программын агуулга, зорилго, Бээжингээс АНУ, Японы талаар мөн түүнчлэн Вьетнам, Лаос, Кампучи, Зүүн Өмнөд Азийн бусад орны талаар баримталж буй гадаад бодлогын чиг шугамын асуудлаар семинарууд зохиогдов.

БНСВУ-ын Нийгмийн ухааны хорооны дэргэдэх Ази, Номхон далайн судлалын газар нь хятадын судлалд зохих ёсоор анхаарч, Марксизм-Ленинизмын институт, ВКН-ын Төв Хорооны дэргэдэх гадаад харилцааны хэлтсийн хятад судлалын товчоо, философи, түүхийн институт зэрэг тус орны эрдэм шинжилгээний байгууллагуудаас Хятадын сэдвээр сүүлийн жилүүдэд зохиосон симпозиумд идэвхтэй оролцов. Ази, Номхон далайн судлалын газар ВКН-ын ТХ-ны дэргэдэх гадаад харилцааны хэлтсийн хятад судлалын товчоотой хамтран Маогийн дараах хятадын нийгэм, улс төрийн байдалд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг 1982 оны 9-р сард Ханой хотноо зохион явуулсан бөгөөд түүнд эрдэм шинжилгээ, улс төр, цэрэг, дипломат болон эдийн засаг, соёлын байгууллагуудын 120 гаруй судлаачид оролцов. Тус бага хурал 1976 оноос 1982 оны сүүлч хүртлэх хугацаанд хятадын эрх баригчдын гадаад бодлого, цаашилбал нийгэм-эдийн засгийн байдал, соёл, урлаг, улс төрийн бодлого, үзэл бодлын тухай асуудлаар эрдэм шинжилгээний 49 илтгэл мэдээллийг сонсч хэлэлцэв. Ази, Номхон далайн судлалын газар 1982 оны 12-р сард хятад судлалын арга зүйн асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал бас хийв. Хуралд оролцогсод Хятадын өнөөгийн байдлын талаар хөрөнгөтний хятад судлаачдын гаргасан бүтээлийг авч үзэн, тэдний үзэл бодол, судалгааны арга барилыг социалист орнууд болон капиталист зарим орны марксист хятад судлаачдын үзэл бодол, судалгааны арга барилтай харьцуулан үзэв. Бид ЗХУ болон ах дүү социалист бусад орны хятад судлаачдаас хятадын тухай бүтээлээ марксист байр суурь, намч, шинжлэх ухааны гүн гүнзгий үндэслэлтэй бичсэнээс олон зүйлийг сурч авсан юм. Тус бага хуралд хэлэлцсэн асуудлууд нь Вьетнамын хятад судлаачид өнөөгийн хятадын судалгаандаа арвин их туршлага хуримтлуулж, хятадад болж буй үйл

* Өгүүллийг бага зэрэг товчлон орчуулж нийтлэв. (Ряд)

явдалд марксист-ленинист ёсоор дүн шинжилгээ хийх аргыг бий болгох, тэднийг яаруу, санаанаасаа зохиосон дүгнэлтэд хүргэхгүй байх, хятадаас олон оронтой харилцаж ирсэн түүхийг хятадын удирдагчид гуйвуулж байгаа шиг хуурамч үг, тактикийн арга мэх хэрэглэхээс зайлсхийхэд чиглэв.

Барууны зарим судлаачид урьд нь Хятадыг үргэлж дүрсээ хувиргадаг «хамелеон» гэж үздэг байв. Одоо зарим нэг судлаач мөн тиймэрхүү үзэл бодлыг баримталж хятадыг үл ойлгогдох орон гэж үзэж байна. Өөр зарим хятад судлаач ЗХУ-д социализм байгуулсан замд сөргүүлэн хятадын удирдлага Хятадад социализм байгуулах шинэ зам «хятадын зам»-ыг эрж хайж байгаа юм гэж нотлохыг оролдож байна. Гэвч бид «Кантын үзэл»-ийг баримтлагчид бишээ. Хятадад болон манай гаригийн бусад зарим хэсэгт болж буй үйл явдалд марксист дүн шинжилгээ хийхийг шаардаж байна. Хятадын бодлогыг хувьсгалч уу, эвсэл хувьсгалч биш үү гэдгийг тодорхойлох гол шалгуур бол энх тайвныг уу, эсвэл дайныг дэмжиж байна уу, пролетарийн интернационализмыг уу, эсвэл их гүрний дээрэнгүй жанжлах үзлийг хэрэгжүүлж байна уу, социалист орнуудын уу, эсвэл империализмын эрх ашигт ажиллаж байна уу гэдгээр хэмжих явдал мөн.

Вьетнамын хятад судлаачид дэлхийн болон хятадын хувьсгалын эрх ашгийг хамгаалах үүднээс хятадын байдлыг авч үзэн, пролетарийн интернационализмыг удирдлага болгон марксизм-ленинизмын байр сууриас судалгааг явуулж байна. Хятад болон Зүүн Өмнөд Азийн орнуудтай Вьетнам хил залгадаг байдал, түүний газарзүйн байрлал, түүнчлэн вьетнам-хятадын харилцаа нь Хятадаас тус бүс нутгийн хувьд явуулж байгаа гадаад бодлогыг сайтар ойлгох бололцоог Вьетнамын хятад судлаачдад олгож байгаа юм. 1982 оны 3-р сард болсон ВКН-ын V их хуралд тавьсан тайлан илтгэлд ВКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ле Зуан «Хятадын эзлэн түрэмгийлж жанжлах үзлийг шүүмжлэн буруушаахад анхаарлаа хандуулах», түүнийг «Маоизмын эсрэг манай жинхэнэ тэмцлийн гол агуулга» болгох зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ. БНХАУ-д болж буй өөрчлөлттэй холбогдуулан «Хятадын төрийн аппарат, нийгэм-эдийн засгийн нэн чухал асуудлаар» 1982 оны 4-р сард Москвад хуралдсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаас хийсэн дүгнэлтүүдтэй бид санал нэгтэй байна.

ХКН-ын ТХ-ны II дэх удаагийн 1978 оны 2-р сард хуралдсан III Бүгд хурлаас 1981 оны 6 сарын ХКН-ын ТХ-ны мөн удаагийн VI бүгд хурал хүртэл «маоизмыг үхширтэл баримтлагсад» (хэт зүүний ч гэж нэрлэдэг) ба «прагматик үзэлтнүүд» гэсэн бүлэглэлийн хоорондын ширүүн тэмцэл үргэлжилж ирснийг бид сайн мэднэ. Заримдаа энэ тэмцэл нь дахин ширүүсэх үедээ орох гэж түр намждаг ч байв. Хятадад Мао Зэдуны үзэл санааны уламжлал, бодлогыг дүгнэх гэж бужигнахдаа нэг бол тэдгээрийг «хамгаалж», эсвэл «хамгаалах, шүүмжлэх»-ийг хослуулж, эсвэл «тэдгээрийг эрс шийдвэртэй шүүмжлэхийг уриалж, үндсэндээ хамгаалж» байв. Судлаачдын үзэж байгаагаар энэ нь маоизмаас бүрэн татгалзсан зүйл биш (бөгөөд харин ч маоизмын мөн чанар буюу Зөвлөлтийн эсрэг их гүрний дээрэнгүй үзлээсээ татгалзаагүй хэвээр байгааг харуулж байна.

Ази, Номхон далайн район дахь олон улсын бодит байдал нь 1982 оны 9-р сард хуралдсан ХКН-ын XII их хуралд Ху Яобаны тавьсан тайлан илтгэлд Хятадаас бусад оронтой харилцааг хөгжүүлэх тууштай зарчим бол бие даасан байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, бие биесийн дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн

орших явдал мөн гэж Хятадын коммунист намын гадаад бодлогын чиг баримжааны тухай мэдэгдэж нийтэлсэн нь худал хуурамч зүйл болохыг илчлэн харуулав. Хятадын суртал нэвтрүүлэг Вьетнамын хилийн мужуудад «Хятад-Вьетнамын найрамдал»-ын тухай өдөр шөнөгүй ярьдаг мөртөө Хятадын цэрэг Вьетнамын хойт хилийн Хоанглиенион, Хагун, Каобанг, Лангшон, Куанг-нинь гэх зэрэг мужуудад цөмрөн орж, мина булж, орон байр байшинг эвдэн сүйтгэж, тариалангийн талбай ойн үнэт мод зэргийг бүрэлгэн устгаж байв. Нэлээд ноцтой өдөөн хатгалга бол энэ оны 4-р сарын 16-нд Хятадын цэрэг өөрийнхөө нутгаас Вьетнамын районууд руу том калиберийн их буугаар байнга ширүүн буудсан явдал юм. Бээжингийн эрх баригчид иймэрхүү гэмт үйлдлээрээ Вьетнамын хилийн мужуудын аюулгүй байдлыг алдагдуулж үйлдвэрлэлд хохирол учруулан энгийн номхон ард иргэдийн амь насанд заналхийлсэн юм. Зөвхөн энэ оны 5-р сарын эхний 7 хоногт Хятадын зэвсэглэсэн хөлөг онгоц Хуангминь муж дахь БНСВУ-ын нутгийн усан хилд 100-гаад удаа халдаж, өөрийнхөө орны усанд загас агнаж байсан вьетнамын загасчдад саад учруулсан юм. Хятадын тал 1983 оны 4-р сарын 23-нд салхины чиглэлийг ашиглан, Вьетнамын Хатуен муж болох Лунгтюфунг, Шаншаго, Банфо, Намлау тосгонуудын хэдэн зуун гектар ойд түймэр гаргажээ. Үүний зэрэгцээ Бээжингийн эзлэн түрэмгийлэгчид Вьетнамын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эвдэн бусниулах үнэнхүү хорон санаат аргыг хэрэглэсээр байна. Тухайлбал, тэд Вьетнамын хилийн мужуудын оршин суугчдыг зэрлэг үхэр, шарын эвэр, туурай, эрдэнэ шишийн үндэс, 1 наст ногоон ургамлын үндэс гэх зэргийг өндөр үнээр худалдахыг ятгаж байна. Энэ бол Вьетнамын эсрэг Дэн Сяо-пин, түүний бүлгийнхнээс улс төр, үзэл суртал, эдийн засаг, соёл, цэрэг, дипломат болон бусад салбарт үйлдэж буй хорт явууллагын нэг хэсэг мөн. Хятадын цэрэг 1974 оны 1-р сард хууль бусаар Вьетнамын Параселийн арлуудыг булаан авч, өнөө хүртэл эзэгнэж байна. Мөн түүнчлэн Хятад нь Вьетнамын харьяаны Спратлийн бүлэг арлыг авах санаархлаа ч орхиогүй юм. Саяхан Бээжин «Өмнөд хятадын тэнгис дэх арлуудын нэрсийн жагсаалт» гэгчийг нийтэлж, түүндээ Вьетнамын дээр дурдсан бүлэг арлыг оруулжээ.

Зүүн өмнөд Азийн орнуудын газар нутаг дахь нефтийн баялагийг дээрэмдэх, тус районд цэргийн хяналтаа бэхжүүлэх зорилгоор Вьетнамын мужуудад хятадын үйлдэж буй өдөөн хатгалга дорнод хятадын тэнгис дэх хятадын явууллага нь улам бүр идэвхжиж, ХКН-ын XII их хурлын индрээс «БНХАУ үүссэнээр бусад орны хувьд хавсарган нийлүүлэх бодлого явуулахын нийгмийн уршгийг арилгаж байна» гэж ёслол төгөлдөр зарласнаас хойш ч бас багассангүй.

Энэ бол тодорхой орон зай, цаг хугацаанд гарсан баримтууд юм. Энэ нь үнэн хэрэгтээ Бээжингийн удирдагчдын өөрсдийн нь хүлээн зөвшөөрснөөр газар нутгийн өнгөлзлөгө, хуурай газар, тэнгист үйлдэж буй эзлэн түрэмгийлэх ажил явууллага мөн бөгөөд харин дан ганц «газрын зураг дээр хийж байгаа дайн» биш юм.

Хятадын «Жэньминь жибао» сонин 1983 оны 2-р сарын 12-ны өдрийн дугаартаа «Хятад улс хэзээ ч бусад орны дотоод хэрэгт оролцоогүй» гэж ХКН-ын ХН их хурал дээр Ху Яобаны мэдэгдсэн зүйлийг умартаж, «Вьетнамын ард түмэнд хандан нийтэлсэн захидал» гэгчдээ БНСВУ-ын засгийн газрыг түлхэн унагаахыг уриалжээ. Вьетнамын ард түмнээс урван тэрсэлсэн Хаонг Ван Хоаныг Бээжин зүйл бүрээр дэмжиж, түүнд хүч сэлбэн, ингэснээрээ Вьетнамыг хятадад хавсарган нийлүүлэх хорон санаархлаа хэрэгжүүлэхийг оролдож байна.

Хятадын одоогийн удирдлагаас Вьетнам, Лаос Кампучийг дайсагнан, америкийн империализм, Япон болон бусад харгис хүчинтэй улс төр, эдийн засаг, цэргийн талаар улам нягт эвсэн хуйвалдаж буй бодлого, Энэтхэг-хятадын хойгийн болон АСЕАН-ы орнуудын хооронд хэлэлцээ хийх хандлага, тус бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг тасалдуулахад чиглэсэн санаарха, Кампучид Пол Потыг оролцуулсан засгийн газрыг байгуулахад Тайландыг талдаа авах оролдлого, «хоёр хэт их гүрний» эсрэг фронт байгуулах зорилгоор «гуравдахь ертөнцийн» орнуудын ойр дотно найз гэж дүрслэн тэднийг энэ фронтод татан оруулахыг оролдож, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд Бээжингийн үйлдэж буй хорт явууллага зэргийг хэн бүхэн мэдэх билээ. Хятадын эдгээр оролдлого, ажил явууллага нь аль хэдийн бодит зүйл болсон бөгөөд эрдэмтдийн таамаглал биш юм. Вьетнамын эсрэг түрэмгий дайнд америкийн империалистууд ялагдсаны дараа бүх Зүүн Өмнөд Ази, тухайлбал Энэтхэг-хятадын хойгийн орнуудын талаар АНУ-ын одоогийн баримталж буй бодлогод Бээжингийн бодлого бодит туслалцаа үзүүлж байгааг нотлож байна. Энэ бол Вьетнамыг л ганцаардуулж, түүнийг эвдэн бусниулахад чиглэсэн Хятад, АНУ-ын дэлхий дахины хэмжээний стратегитай холбоо бүхий бодлого юм.

Бээжингийн удирдлага социалист орнуудын эв санааны нэгдлийг эвдэн бусниулж, социалист хамтын нөхөрлөлийг хагалан бутаргаж сулруулах, ЗХУ, Куба, Монголын эсрэг чиглэсэн бодлогоо огтхон ч өөрчлөөгүй байгаад эргэлзэх зүйл алга. Энэ зорилгодоо хүрэхийн тулд тэд уламжлал болсон улс төр, эдийн засаг, дипломатын хорон санаат арга заль хэрэглэсээр иржээ. Одоо үед хятадын шинэ киссенджерүүд нь Хятадын эртний зальт дипломат Су Цинь, Чжан И нар шиг болчихоод байна. «Ширээний одон бөмбөгийн» дипломат мэх нь маоист стратегчдийн эцсийн арга биш байв. «Дөрвийн бүлэг»-ийг түлхэн унагасан нь 80-аад оны хятадын улс төрийн тавцанд бүлэглэлүүдийн хоорондын эцсийн мөргөлдөөн ч биш байх.

Түүгээр ч үл барам бидний өмнө «Мао Зэдуны үзэл санааг» удирдлага болгосон хятад орон харагдаж байна. Хэдийгээр энэ үзэл санааг «реалистууд» буюу Дэн Сяопин, түүний талынхны бүлэгт ашигтай «өөрчиллөө» ч гэсэн, энэ бүлгийнхэн дэлхийд хятадын удирдах байр суурийг улсын болон үзэл суртлын хувьд олж авах, «Мао Зэдуны үзэл санаа бол манай эрин үеийн марксизм-ленинизмийн оргил мөн» гэсэн чиг шугамыг баримталж байна.

Хятад нь Зүүн Өмнөд Азид ажил явууллагаа улам идэвхжүүлж байгаа бөгөөд учир нь энэ бүс нутаг бол Хятадаас дэлхий дахинд хэрэгжүүлэх стратегид нэн тэргүүн зэргийн ач холбогдол бүхий район юм. Тэнд 20 сая гаруй «Хуа Цяо» (цагаачид) оршин суудаг бөгөөд Бээжин тэднийг цэрэг, эдийн засаг, улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх зэвсэг гэж үзэж байна.

Вьетнамын хятад судлаачид Зөвлөлт Холбоот Улс болон социалист бусад орны хятад судлаачдын хамт БНХАУ-д болж буй хэрэг явдал, түүний гадаад бодлогын үйл ажиллагааг судлан, дүн шинжилгээ хийх ажилд хувь нэмрээ оруулахыг чармайж байна. Хятадаас дэлхий дахинд явуулж буй бодлогыг авч үзэх өргөн нөхцөл бололцоо бидэнд алга. Гэвч Вьетнамын газарзүйн байрлалын байдлаар бид энэ орны тухай мэдсэн зүйлээ дэвшүүлэн тавьж чаднаа. Үүний зэрэгцээ бид ах дүү социалист орнуудын болон мөн түүнчлэн дэлхийн бусад орны марксист хятад судлаачдын мэдээлэл, судалгааны үр дүнг ихээхэн анхааран үздэг юм.

Вьетнамын хятад судлаачид нь манай орныг газарзүйн хувьд ганцаардуулж буй нөхцөлд Хятадыг ажиглаж байна. Гэхдээ, гол нь судалгаа хийгчийн үзэл бодолд байгаа бөгөөд харин түүний хаана байхад биш юм. Эртний ба дундад зууны үед, феодалын дэглэмийн нөхцөлд Хятад-Вьетнамын харилцааны түүх нь ямагт «түрэмгийлэгч» «түрэмгийлэгчдийн эсрэг» түүх байсан нь тодорхой билээ. XIX зууны дундаас Вьетнам, Хятадын аль аль нь Өрнөдийн түрэмгийлэгчдийн халдлагад өртсөн юм. Хоёр орон хоёулаа хагас колони, хагас феодалын улс болов. Тэдний хувь заяа адилхан байв. Тэр үеэс эхлэн эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хоёр орны ард түмний хувьсгалт тэмцлийн түүхийн хуудас, мөн түүнчлэн Вьетнам, Хятадын хувьсгалчдын хоорондын нөхөрлөл, эв санааны нэгдэл, харилцан туслалцах түүхийн хуудас нээгдсэн юм.

Хэрэв хятадын эрх баригчид Вьетнамыг дайсагнасан бодлого, ажиллагаа явуулж, хоёр орны ард түмний найрамдал, хамтын ажиллагааг тасалдуулаагүйсэн бол Вьетнам, Хятадын ард түмнүүдийн хоорондох найрамдал, хамтын ажиллагаа нь хоёр орны ард түмний болон дэлхийн хувьсгалын эрх ашигт нийцэж хөгжин бэхжих ёстой байсан юм. Хятадын дээрх бодлогын зуршил болсон ичгүүр сонжуургүй илрэл бол хятадын цэрэг 1979 оны 2-р сард Вьетнамын хойт хилийн зургаан мужид томоохон хүчээр халдан довтолсон явдал юм. Хэрэв Вьетнамын хятад судлаачид Хятадын удирдлагаас өнөөгийн Вьетнамын талаар явуулж буй бодлогыг эрт дээр үед Вьетнамын эсрэг хятадын үйлдэж байсан зэрлэг балмад түрэмгийллийн хүнд хор уршгийн үүднээс авч үзвэл алдаа хийж, түүхийн асуудалд марксист ёсоор хандах үзэл бодолд харшилна. Эрт дээр үед Хятадаас Вьетнамын эсрэг үйлдэж байсан түрэмгийллийн хариуцлагыг хятадын феодалын хүнд суртлын дэглэм л хүлээх билээ. Энэ асуудалд бидний баримталж буй хандлага зөв бөгөөд тодорхой юм: «Бид Цезарьт ноогдсон юмыг Цезарьт л ноогдуулна». Хятадын одоогийн удирдлага өөрийн явуулж буй бодлогын хариуцлагыг хүлээх ёстой.

Харин МЭӨ VII зуунд Чжоугийн хаанчлалын үед эртний Хятадад үүсч бий болсон бөгөөд философийн нэр томъёонд жанжлал гэж нэрлэгддэг «Тэнгэрийн доорхи эзэнт улс» гэсэн үзэл бүрэлдэн тогтсоны улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл, мөн түүнчлэн хятадын жанжлалаас үлдээсэн хүнд өвийг сайтар судлах хэрэгтэй юм. Мао Зэдун болон түүний талынхан уг өвийг уламжлан авч улам өргөтгөхийг эрмэлзэж байв. Маоизмыг бүтээгчид ч «соёлын хувьсгал»-ын үед зүүний нугалаанаас болж дампууралд орсон бодлогоос Маог нас барсны дараах жилүүдэд зохих сургамж аваад байна.

Хятадын удирдлага Хятадыг дэлхийд жанжлагч гүрэн болгох чиг шугамаа хэрэгжүүлэх зорилгоор дотоод, гадаад бодлогоо засварлах буюу түүнийхээ хэлбэр дүрсийг хувиргаж байгааг бид улам тод харж байна. Энэ бол өнөөгийн Вьетнамын хятад судлаачдын анхаарлын төвд байдаг асуудал юм.